



Хувьцааны мэдээлэл

Ханш /2025.01.28/	838,99₮
Target price	995.59₮
Тикер	MSE:XAS
52 долоо хоног	663.66 – 899.85₮
Зах зээлийн үнэлгээ	882.74 тэрбум ₮
Нийт хувьцааны тоо	1,052,700,000
EPS	162.37
P/B	1.21
P/E	5.16

Хувьцаа эзэмшигчдийн бүтэц



Банкны хувьцааны ханшийн хөдөлгөөн



“Хас Банк” ХК

BUY

Target price/2025.12.31/: 995.59₮

Компанийн тухай

“Хас Банк” ХК нь 2001 он байгуулагдсан ба Монгол Улсын системийн таван банкны нэг нь билээ. Банк нь нийт 71 салбар нэгж, 1,152 мэргэшсэн ажилтантай үйл ажиллагаа явуулж байгаа ба банкны нийт харилцагчийн тоо 1 сая орчим байна.

Хас банкны 2024 оны онцлох үйл явдлууд:

- Олон улсын банк, санхүүгийн байгууллагуудаас нийт 176 сая ам.долларыг амжилттай татан төвлөрүүлсэн
- Moody's агентлаг Банкны зээлжих зэрэглэлийг **B2/тогтвортой** болгон нэг шат сайжруулсан
- Жижиг хувьцаа эзэмшигчдийн хувьцааны хөрвөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор нээлттэй зах зээлд гаргасан хувьцаанаас тодорхой хэсгийг эргүүлэн худалдан авч халааслах хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн

Системийн 5 банкны төлөв байдал




“Хас Банк” ХК-ийн нийт активын хэмжээ 2024 оны жилийн эцсийн байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.2 их наяд төгрөгөөр буюу 23.4% хувиар өсөж 6.3 их наяд төгрөгт хүрсэн байна. Хас банк нь нийт активын хэмжээгээрээ системийн таван банктай харьцуулахад 4-т жагсаж байгаа бөгөөд нийт банкны салбарын 8.8% хувийг дангаараа эзэлж байна. Ашигт ажиллагаагаараа Хас Банк нь Хаан болон Голомт банкуудын араас орж гуравт жагсаж байна.

Банкны хувьцааны үнэ 2025 оны 01 сарын 28-ны өдрийн байдлаар 838.99 төгрөг байгаа бөгөөд анх гарсан IPO үнээс (677 төгрөг) 23.9% хувийн өсөлттэй байна.



	ROA	ROE	P/B	Нийт хөрөнгө*	Цэвэр ашиг*
Khan	3.2%	26.3%	0.9	20,302.7	638.5
TDB	2.0%	20.3%	0.9	15,016.0	300.1
GLMT	2.6%	32.1%	0.8	15,410.2	407.3
SBM	1.7%	17.1%	0.6	6,218.5	108.0
XAC	3.0%	25.3%	1.2	6,317.7	170.9
Дундаж	2.4%	24.3%	0.9	12,653.0	324.94

*тэрбум ₮

САНХҮҮГИЙН ШИНЖИЛГЭЭ



Үндсэн үйл ажиллагааны үзүүлэлтүүд



Огноо	2020	2021	2022	2023	2024
Салбарын дундаж чанаргүй зээл, %	10.4%	9.0%	8.4%	6.8%	4.5%

Ашигт ажиллагааны үзүүлэлтүүд /ROA,ROE/

Банкны өөрийн хөрөнгө 2024 оны байдлаар 731 тэрбум төгрөг байгаа ба өмнөх оны мөн үеэс 17.5% хувиар өссөн. Харин банкны өөрийн хөрөнгийн өгөөж 2021 оноос хойш 20 хувиас дээш байгаа бөгөөд 2024 оны жилийн эцсийн байдлаар 25.3% хувь байна. Хас банкны нийт активын өгөөж салбартаа өндөр байгаа ба 2024 оны байдлаар 3.0% хувьтай гарчээ.

Хүүгийн орлогын маржин

2024 оны эцсийн байдлаар Хас банкны хүүгийн орлого өмнөх онтой харьцуулахад 32.3% хувиар өсөж 713 тэрбум төгрөгт хүрсэн бол хүүгийн зардал 44.7% хувиар өсөж 403 тэрбум төгрөг хүрсэн байна. Ингэснээр хүүгийн орлогын маржин 0.3% хувиар буурчээ.

Цэвэр ашгийн маржин

Хас банкны цэвэр ашиг сүүлийн таван жилд дунджаар 38.4% хувийн өсөлт үзүүлсэн ба 2024 оны байдлаар цэвэр ашиг 170 тэрбум төгрөгт хүрчээ. Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад банкны цэвэр ашиг 20% хувийн өсөлт үзүүлсэн бөгөөд энэ нь өмнөх онуудын цэвэр ашгийн өсөлттэй харьцуулахад бага зэрэг буурсан үзүүлэлт юм. Цэвэр ахиуц ашиг өмнө жилийн эцэстэй харьцуулахад 2.2% хувиар буурсан байна.

Үндсэн үйл ажиллагаа

2024 оны байдлаар Хас банкны нийт цэвэр зээл 3.6 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 30.7% хувиар буюу 835 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна. Нийт зээлийн 2.0% хувь нь буюу 74.3 тэрбум төгрөг чанаргүй зээлийн ангилалд орсон байгаа ба өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад чанаргүй зээлийн хувь 1.0% хувиар буурсан байна. Нийт банкны салбарын дундаж чанаргүй зээлийн хувьтай харьцуулахад Хас Банкны чанаргүй зээлийн хувь 2.5% хувиар бага байна. Хас банкны зээлийн эрсдэлийн сангийн хэмжээ 2024 оны жилийн эцсийн байдлаар 57.5 тэрбум төгрөг байгаа ба өнгөрсөн оны мөн үеэс 5 тэрбум төгрөгөөр багассан байна. Ийнхүү 2023 оны байдлаар зээлийн эрсдэлийн сангийн нийт чанаргүй зээлд эзлэх хувь 91.3% хувь байсан бол 2024 оны байдлаар уг харьцаа 77.5% хувь хүртэл буурсан байна.

Банкны харилцах, хадгаламжийн хэмжээ 2024 оны байдлаар 3.4 их наяд төгрөгт хүрч өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 19.1% хувиар буюу 549 тэрбум төгрөгөөр өссөн байна. Банкны зээл хадгаламжийн харьцаа 2020 оноос хойш тасралтгүй өссөөр 2024 байдлаар 107.6% хувь болжээ. Энэ нь банк зээл олголтоо санхүүжүүлэх зорилгоор бусад эх үүсвэр ашиглаж байгааг илтгэж байна.

Дүгнэлт

P/B болон P/E харьцаанууд дээр үндэслэхэд Хас Банкны хувьцааны зах зээлийн үнэлгээ 2024 оны 4-р улирлын байдлаар доогуур үнэлэгдсэн хэвээр байгаа ба банкны ашигт ажиллагаа болон эрсдэлийн удирдлага зэргийг авч үзэхэд хувьцааны үнэ цаашид өсөх боломжтой гэж таамаглаж байна.